

**“МОНГОЛЫН РАДИОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-2025” -д эрдэм  
шинжилгээний бүтээлийн хураангуй (абстракт), эмнэлзүйн тохиолдол  
хүлээн авах тухай**

**Илтгэлийн хураангуй бичих заавар**

1. Илтгэлийн сэдэв аль болох товч, үндсэн агуулгыг илэрхийлсэн байна. Зөвхөн эхний үсгийг томоор, тод хараар (Bold) бичигдсэн байна. 14pt үсгийн өндөртэй, мөр голлон бичих ба Sentence case тохиргоотой байна. Дэд гарчгууд (хураангуй, түлхүүр үг, удиртгал, үндсэн хэсэг, ном зүй г.м) нь 12pt үсгийн өндөртэй, bold форматаар зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) бичнэ.
2. Зохиогч нарын нэр, албан газрын нэрийг гарчигны доор бичнэ.
3. Зохиогчдын овог, нэр нь 10pt үсгийн өндөртэй, bold форматтай, баруун тал руу зэрэгцүүлсэн (align right) байна. Зохиогчдын тухай мэдээлэл оруулахдаа овог, нэрийн баруун дээд өнцөгт тоогоор тэмдэглэж, түүний доод мөрнөөс мэдээллийн дэлгэрэнгүйг бичих ба мэдээллийн өмнө харгалзах дугаарыг бичнэ.

Жишээ нь:

**Х. Хүрэл<sup>1</sup>**

*<sup>1</sup>ЭХЭМҮТ, Радиологийн тасаг*

Байгууллагын нэрийг шинэ мөрнөөс 10pt үсгийн өндөртэй, Italic форматтайгаар баруун тал руу зэрэгцүүлэн (align right) бичнэ. Олон зохиогчтой бол хариуцлагатай зохиогчийн нэрийн баруун дээд өнцөгт \* тэмдэгтийг давхар байршуулна.

Товч танилцуулгад цахим шуудангийн хаягийг заавал, зохиогчид хэрэв ORCID хаяг байгаа бол оруулна.

6. Хураангуй нь Монгол, Англи хэлээр бичигдсэн байна. Хураангуйд үндсэн баримт, дүгнэлтийг агуулсан 300 үгээс хэтрэхгүй байна.
7. Үндсэн бичвэр А4 хэмжээтэй бичгийн цаасан дээр бүх талаасаа 2,5 см зайд, Microsoft word программын Arial фонтоор нь 11pt үсгийн өндөртэйгээр regular форматаар, хоёр талдаа тэгшилсэн (justified) байдлаар бичнэ.
8. Түлхүүр үг: Гурваас таван үгийг багтаасан Монгол болон Англи хэлээр бичигдсэн байна. Түлхүүр үг гэсэн нэр томъёо нь 12pt үсгийн өндөртэй, bold, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) бичнэ. Түлхүүр үгийн бичвэрийг regular форматаар 12pt үсгийн өндөртэйгээр бичнэ.
9. Ном зүйн жагсаалтыг Ном зүйг APA (American Psychological Association) загвараар, ашигласан ном, зохиол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, бүтээл, сонин, сэтгүүлээс авсан материал, вэб хуудас, видео бичлэг г.м. эх сурвалжийн нэрсийг жагсаан бичнэ. Ном зүйг EndNote зэрэг зориулалтын программыг ашиглан бичих нь оновчтой. Arial фонтоор 10 үсгийн хэмжээтэй цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ.

**10. Хүснэгт, зургийн шаардлага**

Хүснэгтийн дугаар, гарчиг нь тод хараар (Bold), 11pt (size) үсгийн хэмжээтэй, хоёр талдаа тэгшилсэн (justified), мөр хоорондын зай 1pt байна.

Хүснэгт доторх бичвэр нь ердийн (regular style), 11 pt (size) хэмжээтэй, мөр хоорондын зай 1pt байх бөгөөд зөвхөн Монгол хэлээр бичигдэнэ. Зайлшгүй шаардлагатай нэр томъёог гадаад хэлээр ашигласан тохиолдолд нэмэлт тайлбарыг хүснэгтийн дор бичнэ.

Хүснэгтийн загварт тодорхой хязгаарлалт тогтоохгүй.

Хүснэгтийг хуудас дамнуулан бичихгүй ба зурган файл болгохгүй. Хэрэв хүснэгтийг бүхэлд нь бусад судлаачийн бүтээлээс хуулбарлан авсан бол мэдээллийн эх

сурвалжийг заавал хүснэгтийн доод хэсэгт бичих ба зохиогчоос хуулбарлах зөвшөөрлийг бичгээр авсан байх шаардлагатай. Хэсэгчилсэн мэдээллийг ашигласан бол эх сурвалжийг дурдана.

Хүснэгтийг гар бичмэлд байршуулж болохоос гадна Microsoft Excel хэлбэрээр ирүүлнэ.

## 11. Зураг

Зураг гэдэгт бүдүүвч, схем, график, диаграмм, фото зураг зэрэг багтана. Зургийн дугаар, нэр нь зургийн доод хэсэгт байрлах ба тод хараар (Bold), 11pt (size) үсгийн хэмжээтэй байна. Фото зургийг 300-аас дээш dpi нягтралтайгаар JPEG өргөтгөлтэйгээр тусад нь илгээнэ. Бүдүүвч, схем, график, диаграммыг гар бичмэлд байршуулна.

## Эмнэлзүйн тохиолдолын хураангуй бичих загвар

1. Эмнэлзүйн тохиолдлын сэдэв аль болох товч, үндсэн агуулгыг илэрхийлсэн байна. Зөвхөн эхний үсгийг томоор, тод хараар (Bold) бичигдсэн байна. 14pt үсгийн өндөртэй, мөр голлон бичих ба Sentence case тохиргоотой байна. Дэд гарчгууд (хураангуй, түлхүүр үг, удиртгал, үндсэн хэсэг, ном зүй г.м) нь 12pt үсгийн өндөртэй, bold форматаар зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) бичнэ.
2. Зохиогч нарын нэр, албан газрын нэрийг гарчигны доор бичнэ.
3. Зохиогчдын овог, нэр нь 10pt үсгийн өндөртэй, bold форматтай, баруун тал руу зэрэгцүүлсэн (align right) байна. Зохиогчдын тухай мэдээлэл оруулахдаа овог, нэрийн баруун дээд өнцөгт тоогоор тэмдэглэж, түүний доод мөрнөөс мэдээллийн дэлгэрэнгүйг бичих ба мэдээллийн өмнө харгалзах дугаарыг бичнэ.
4. Жишээ нь:

Х. Хүрэл<sup>1</sup>

<sup>1</sup> ЭНЭМҮТ, Радиологийн тасаг

5. Байгууллагын нэрийг шинэ мөрнөөс 10pt үсгийн өндөртэй, Italic форматтайгаар баруун тал руу зэрэгцүүлэн (align right) бичнэ. Олон зохиогчтой бол хариуцлагатай зохиогчийн нэрийн баруун дээд өнцөгт \* тэмдэгтийг давхар байршуулна.
6. Товч танилцуулгад цахим шуудангийн хаягийг заавал, зохиогчид хэрэв ORCID хаяг байгаа бол оруулна.
7. Эмнэлзүйн тохиолдлын товч утгыг/ абстракт/ англи хэл дээр 200 үгэнд багтаан бичнэ.
8. Эмнэлзүйн тохиолдолын удиртгал: тодорхойлолт, бичих үндэслэл, урьдчилсан дүгнэлт,
9. Эмнэлзүйн тохиолдлын танилцуулга
  - Өвчтөний товч мэдээлэл.
  - Биеийн ерөнхий байдал болон амьдралын түүхийг танилцуулах.
  - Бодит үзлэг
  - Бусад шинжилгээ
  - Онош
  - Эмчилгээ

10. Хэлцэмж

11. Дүгнэлт

12. Ном зүй

- Эмнэлзүйн тохиолдлыг Монгол хэлээр бичсэн байна.
- Эхийг А4 хэмжээтэй бичгийн цаасан дээр бүх талаасаа 2,5 см зайд, Microsoft word программын Arial фонтоор, үсэгний хэмжээ 12-ээр, мөр хоорондын зай single, 1,5-2 нүүрт багтсан байна.
- Илтгэлийн нэрийг үсгийн 14 хэмжээтэй, том үсгээр, BOLD байх.
- Зохиогч нарын нэр, албан газрын нэрийг гарчигны доор бичнэ.

- Ном зүйн жагсаалтыг Arial фонтоор 10 үсгийн хэмжээтэй цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ.
- Илтгэлд оруулсан фото зураг, график, диаграмм нь тод ялгарах контрасттай байх ба JPG өргөлттэй электрон хэлбэрээр хавсаргаж явуулна.
- Эмнэлзүйн тохиолдлын хураангуй эхийг файл хэлбэрээр доорх хаягаар хүлээн авна.

**Материал хүлээн авах:**

MCR-2025 чуулганы материалыг [mcr.mongolia@gmail.com](mailto:mcr.mongolia@gmail.com) цахим шуудангаар хүлээж авна.

**Хугацаа: 2025 оны 5-р сарын 01-ны өдөр хүртэл**

**Нийтлэг анхаарах зүйлс:**

Эрдэм шинжилгээний илтгэлийн хураангуй, эмнэлзүйн тохиолдол хүлээж авах хугацаа дууссаны дараа шүүгчид шүүн тунгааж, “ Радиологи” сэтгүүлийн тусгай дугаарт хэвлэгдэх, аман илтгэл тавих, e-poster хэлбэрээр тавигдах талаар заагдсан хугацаанд утсаар болон email хаягаар мэдэгдэх тул [mcr.mongolia@gmail.com](mailto:mcr.mongolia@gmail.com) хаягаар бүтээлээ илгээхдээ өөрийн товч танилцуулга/ овог нэр, мэргэжил, ажил, харьяалагдах албан байгууллага, холбогдох утас, email/ хуудсыг заавал давхар илгээнэ үү.

Сэтгүүлийн зөвлөл өгүүлэлийн утгыг алдагдуулалгүй засах, боловсруулалт хийх боловч зохиогчийн эрхийг хүндлэх ба шаардлага хангаагүй материалыг нийтлэхгүй. Хэвлэлд орсон материалыг буцаахгүй.

Бусад сэтгүүл, хэвлэлд гарсан материалыг хүлээн авахгүй.

**Холбоо барих утас: 88817989, 90007161, 88010233, 95959279, 9907-5546**